

ШИЙДВЭРЭЭРЭЭ ЯЛГАР

Үнэт цаас гаргагч



Андеррайтер



Хөндлөнгийн
хуулийн зөвлөх

DB>S

Зээлийн шинжилгээ
гаргагч



Хөрөнгө итгэмжлэн
удирдагч



БИЧИЛ ГЛОБУС

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

Нийт үнийн дүн

10.0 тэрбум ₮

Нэрлэсэн үнэ

100,000 ₮

Хүү

17.5%

Хугацаа

24 Сар

Хүү төлөгдөх хэлбэр

Улирал тутам

Үндсэн төлбөр

Хагас жил тутам



ТА ӨӨРИЙН САНХҮҮГИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ ШИЙДВЭРЭЭРЭЭ ЯЛГАР

Бүх зам Ром ордог гэдэг шиг бүхий л санхүүгийн хэрэгслүүд тодорхой хэмжээний эрсдэлийг дагуулж байдаг. Жишээ нь бидний сайн мэдэх, хамгийн аюулгүй гэж боддог банкны хадгаламжийн талаар авч үзье. 2022 оны байдлаар инфляц 14.5%, дундаж хадгаламжийн хүү 12.5% байна. Энэ нь та мөнгөө өсгөхөөр хадгаламжид байршуулсан хэдий ч таны мөнгө жилийн дотор 2 хувиар үнэ цэнээ алдана гэсэн үг юм. Иймд хөрөнгө оруулалтын эрсдэлүүдийг тань бууруулж, санхүүгийн зөв шийдвэр гаргахад тань туслах зорилгоор хөрөнгө оруулалтын зөвлөх, мэргэжлийн компаниуд бид оршин тогтнодог билээ.



КОМПАНИЙН ТУХАЙ

“Бичил Глобус Финанс ББСБ” ХХК нь 2008 оноос эхлэн жижиг дунд бизнес эрхлэгч болон иргэдэд зориулан шуурхай зээлийн үйлчилгээг үзүүлэхээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өдгөө тус компани нь нийслэл, орон нутгийн 17 салбар, төвүүдээр дамжуулан санхүүгийн цогц үйлчилгээг 6,000 гаруй харилцагчдадаа мэргэжлийн өндөр түвшинд хүргэн ажиллаж байна. Мөн тус компани нь 2021 оны “Шилдгийн шилдэг ББСБ”-аар шалгарч, сүүлийн жилүүдэд үйл ажиллагаа нь хурдацтай тэлж буй санхүүгийн зах зээл дэх ууган компани билээ.


БИЧИЛ ГЛОБУС ХБҮЦ-НЫ ТУХАЙ

Бичил Глобус ХБҮЦ нь 100% хэвийн төлөлттэй автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан ба хөрөнгө оруулагч нь уг **хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжид төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас юм.** Энэхүү үнэт цаас нь эдийн засгийн нөхцөл байдал тогтворгүй байгаа энэ цаг үед хадгаламжийг орлох эрсдэл бага, өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл гэдгээрээ давуу талтай.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


НИЙТ ХӨРӨНГӨ

CAGR /Компани/ = 41.8%
CAGR /Салбар/ = 28.2%




ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

CAGR /Компани/ = 39.3%
CAGR /Салбар/ = 22.6%




ХҮҮГИЙН ОРЛОГО

CAGR /Компани/ = 41.8%
CAGR /Салбар/ = 28.2%



ЦЭВЭР АШИГ

CAGR /Компани/ = 39.3%
CAGR /Салбар/ = 22.6%




Энэхүү графикаас харвал сүүлийн 4 жилийн хугацаанд Банк бус санхүүгийн салбар 28.2 хувиар өссөн бол “Бичил Глобус Финанс ББСБ” ХХК-ийн хувьд 41.8 хувиар өссөн байна. Санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг илэрхийлэх бусад голлох үзүүлэлтүүд болох өөрийн хөрөнгө, хүүгийн орлого, цэвэр ашгийн өсөлт ч мөн адил салбарын өсөлтөөс илүү өндөр байгааг харуулж байна.

ТА ӨӨРИЙН САНХҮҮГИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ ШИЙДВЭРЭЭРЭЭ ЯЛГАР

“Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн харилцагчдадаа мэргэжлийн өндөр түвшинд үйлчилгээ үзүүлэх, нөгөө талаас хөрөнгө оруулагч талдаа эрсдэл бага, тэдгээрийн эрх ашиг нэн тэргүүнд тавигдсан бүтээгдэхүүн санал болгох ёстой гэсэн үүднээс ажиллаж ирсэн билээ. Энэ агуулгад бүрэн нийцсэн бүтээгдэхүүн бол тус компанийн андеррайтераар ажиллаж буй “Бичил Глобус ХБҮЦ” (Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас) юм.

ХБҮЦ БОЛОН ХАДГАЛАМЖИЙН ХҮҮГИЙН ТҮВШИН



Хадгаламжийг орлох эрсдэл бага өгөөж өндөр хөрөнгө оруулалт

Бичил Глобус ХБҮЦ-ны хүүгийн хувь хэмжээ нь 2 жилийн хугацаатай хадгаламжийн дундаж хүүтэй харьцуулахад жилийн ойролцоогоор 5 нэгжээр өндөр байна.

Мөн улирал тутам хүүгийн орлогоо хүлээн авах ба хүлээн авсан хүүгийн орлогоороо дахин хөрөнгө оруулалт хийвэл жилд нийт өгөөж 20.5% хүртэл нэмэгдэх боломжтой.

ЖИШЭЭ ТООЦООЛОЛ: ₮10 сая



ДАХИН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НӨХЦӨЛ

Хүүгийн орлогоороо: **ҮГҮЙ**

Үндсэн төлбөрийн эргэн төлөлтөөс: **ҮГҮЙ**

ТАНЫ ХҮЛЭЭН АВАХ МӨНГӨ

ҮНДСЭН ТӨЛБӨРИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ

ХҮҮГИЙН ОРЛОГО

ОГНОО

437,500		437,500	3/1/2023
2,937,500	2,500,000.0	437,500	6/1/2023
328,125		328,125	9/1/2023
2,828,125	2,500,000.0	328,125	12/1/2023
218,750		218,750	3/1/2024
2,718,750	2,500,000.0	218,750	6/1/2024
109,375		109,375	9/1/2024
2,609,375	2,500,000.0	109,375	12/1/2024

12,187,500

НИЙТ

ДАХИН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НӨХЦӨЛ

Хүүгийн орлогоороо: **ТИЙМ**

Үндсэн төлбөрийн эргэн төлөлтөөс: **ТИЙМ**



ХҮҮГИЙН ОРЛОГО

ҮНДСЭН ТӨЛБӨРИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ

ТАНЫ ХҮЛЭЭН АВАХ МӨНГӨ

437,500		0
456,641	2,500,000.0	0
476,619		0
497,471	2,500,000.0	0
519,235		0
541,952	2,500,000.0	0
565,662		0
590,410	2,500,000.0	14,085,488

14,085,488

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДАВУУ ТАЛ

1 ТОГТМОЛ, ӨНДӨР ӨГӨӨЖТЭЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Бичил Глобус ХБҮЦ-ны хүүгийн хувь хэмжээ 17.5% байгаа нь 2 жилийн хугацаатай хадгаламжийн хүүтэй харьцуулахад дунджаар 5 нэгжээр өндөр байна.

2 БОДИТ ӨГӨӨЖИЙН ТҮВШИН ӨНДӨР

Хөрөнгө оруулагч нь 24 сарын хугацааны турш “Бичил Глобус” ХБҮЦ-ны хүүгийн орлогыг улирал тутам, үндсэн төлбөрийг хагас жил тутам хүлээн авах бөгөөд хүлээн авсан хүүгийн орлого болон үндсэн төлбөрөө дахин хөрөнгө оруулалт хийх замаар өгөөжийн түвшнийг жилийн 20.5% хүртэл нэмэгдүүлэх боломжтой.

3 ЭРСДЭЛ БАГА, НАЙДВАРТАЙ БАЙДАЛ

ХБҮЦ нь 100% хэвийн төлөлттэй автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан ба хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь хугацаа хэтэрсэн, шалгуур үзүүлэлт хангахгүй болсон тохиолдолд шууд хэвийн зээлээр тухайн хөрөнгийг солих, нэмэгдүүлэх, хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах гэсэн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалсан нөхцөлүүдтэй.

4 ТАТВАРЫН ТААТАЙ НӨХЦӨЛ

Хаалттай бонд болон Банкны хадгаламжийн хүүгийн орлогоос 10% татвар суутгадаг бол нээлттэй ХБҮЦ-ын хүүгийн орлогын татвар 5% байгаа нь хөрөнгө оруулагчдад таатай боломжийг бүрдүүлж байна.

5 ХӨРВӨХ ЧАДВАР ӨНДӨР

Бэлэн мөнгөний хэрэгцээ гарч хадгаламжийг хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд эзэмшсэн хүүгийн хувь хэмжээ огцом буурдаг бол “Бичил Глобус” ХБҮЦ-ыг Монголын Хөрөнгийн Бирж дээр үнэт цаасны компаниар дамжуулан хугацаанаас өмнө худалдан борлуулах боломжтой ба энэ тохиолдолд тохиолдолд эзэмшсэн хугацааны хүүг 100% олгоно.

1**ҮЦ-ны данс нээлгэх**

Андеррайтер
"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК
болон МХБ-д бүртгэлтэй үнэт
цаасны компаниудаас сонгон
дансаа биеээр эсвэл онлайнаар
нээлгэнэ.

2**Мөнгөө байршуулах**

Өөрийн нэрийн үнэт цаасны
дансанд мөнгөө байршуулна.
Заавар болон дансны
дэлгэрэнгүй мэдээллийг үнэт
цаасны компаниас хүлээн авна.

3**Захиалга өгөх**

Өөрийн сонгосон үнэт цаасны
компанид Бичил Глобус ХБҮЦ
худалдаж авах захиалга өгнө.

4**Баяр хүргэе**

Та эрсдэл бага, өндөр өгөөжтэй
Бичил Глобус ХБҮЦ эзэмшигч
боллоо.

ХБҮЦ Захиалга өгөх**ХБҮЦ Захиалга өгөх**

🌐 bichil.abs.mn

🌐 www.tdbsecurities.mn

☎ 7010-0261, 8008-8706, 8008-8704